



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Залуучууд театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/117/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Дархан-Уул аймаг  
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”**

**ХХК**

Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАЛУУЧУУД  
ТЕАТРЫН ДАРГА А.БОЛОРСҮХ  
ТАНАА

2022.02.25 № 143  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Залуучууд театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Залуучууд театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯА



009020254

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

|                                                | Үзүүлэлт                                          | 2020.12.31                     | 2021.12.31                     |
|------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                                |                                |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | <u>311,648,847.84</u>          | <u>406,950,527.10</u>          |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | <u>5,975,811,714.03</u>        | <u>5,824,532,174.34</u>        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <u><b>6,287,460,561.87</b></u> | <u><b>6,231,482,701.44</b></u> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             | <u>17,037,523.66</u>           | <u>7,870,405.66</u>            |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | <u>6,270,423,038.21</u>        | <u>6,223,612,295.78</u>        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <u><b>6,287,460,561.87</b></u> | <u><b>6,231,482,701.44</b></u> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                                |                                |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,358,569,360.00               | 1,590,817,301.00               |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 1,582,269,422.37               | 1,637,225,169.43               |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <u><b>(223,700,062.37)</b></u> | <u><b>(46,407,868.43)</b></u>  |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        |                                | (402,874.00)                   |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <u><b>(223,700,062.37)</b></u> | <u><b>(46,810,742.43)</b></u>  |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                                |                                |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 6,494,123,100.58               | 6,270,423,038.21               |
|                                                | Тайлант оны үр дүн                                | (223,700,062.37)               | (46,810,742.43)                |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | 6,270,423,038.21               | 6,223,612,295.78               |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                                |                                |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | <u>1,329,214,269.50</u>        | <u>1,484,104,100.00</u>        |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | <u>1,318,165,669.50</u>        | <u>1,472,663,200.00</u>        |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <u><b>11,048,600.00</b></u>    | <u><b>11,440,900.00</b></u>    |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <u><b>(11,038,600.00)</b></u>  | <u><b>(11,450,900.00)</b></u>  |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | -                              | -                              |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  |                                |                                |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                              | 10,000.00                      |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,000.00                      | -                              |
|                                                | <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>                | -                              | -                              |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | 1,433,166,700.00               | 1,410,947,047.53               |
|                                                | Урсгал зардал                                     | 1,433,166,700.00               | 1,410,947,047.53               |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                                |                                |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | 1,433,166,700.00               | 1,432,615,152.47               |
|                                                | Орон нутгийн төсвөөс                              | 1,427,166,700.00               | 1,418,447,452.47               |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | 6,000,000.00                   | 14,167,700.00                  |

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Залуучууд театрын тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилт, түүний хэрэгжилтийн талаарх товч мэдээлэл:

Дархан-Уул аймгийн Залуучууд театр нь “Иргэд олон нийтэд урлаг соёлыг түгээж сурталчилахад манлайлах үүрэг гүйцэтгэж, орчин үеийн цаашлаад олон улсын жишигт нийцсэн уран бүтээл үйлдвэрлэх, судалгаа арга зүйн үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл хоёр хувиар нэмэгдсэн.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн Дархан сумын Залуучууд театрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 407,857.7 мянган төгрөгийн 136 нэр төрлийн хөрөнгө болон улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,581,439.2 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдалд дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

## Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,544.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,544.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

1. Сайнуу мөрөөдөл минь НҮТББ-аас чихэвчний микрофон үнэ 2,500,000.00 төгрөгийг татварын цахим баримтгүй худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
2. Тайлант хугацаанд 6 албан хаагчид нийт 44,428.82 төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэнтэй нийцэхгүй байна.

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | НИЙТ                        | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |

